

БАТЛАВ.

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

2025 он 11 сарын 14-ны өдөр

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН

ДААЛГАВАР

2025 оны 11 дугаар сарын 14

Дугаар

Улаанбаатар хот

1.	Үндэслэл	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 7.3 дахь хэсэг
2.	Зорилго, зорилт	Бодлогын баримт бичгийн үр дүнг хэмжих, бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, байгууллагын хүлээх үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, ил тод байдлыг хангах
	Хамрах хүрээ	Дараах бодлогын баримт бичгийг хамруулна. Үүнд. 1.Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг буюу "Алсын хараа 2050" хөтөлбөрийн дүүрэгт хамаарах заалтын хэрэгжилт, үр дүн; 2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийн дүүрэгт хамаарах заалтын хэрэгжилт, үр дүн; 3.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дүүрэгт хамаарах заалтын хэрэгжилт, үр дүн; 4.Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн; 5.Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн; 6.Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн; 7.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн; 8.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн; 9.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн;
	Мэдээллийн эх сурвалж	Үнэлгээнд ашиглах өгөгдөл цуглуулах: - Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ТГУХ-ээс

		- Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг ХЭЗХ-ээс - Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг ТГУХ-ээс - Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг ТЗУХ-ээс - Холбогдох мэдээлэл, нотломжийг хариуцсан хэлтсүүдээс тус тус эх сурвалжийг бүрдүүлнэ.
	Гүйцэтгэх ажлын цар хүрээ	Анхан шатны судалгаа хийх үе шат: - 2025 оны 11 дүгээр сарын 17-18-ны өдөр Өгөгдөл цуглуулах үе шат: - 2025 оны 11 дүгээр сарын 18-20-ны өдөр Боловсруулалт хийх үе шат: - 2025 оны 11 дүгээр сарын 20-25-ны өдөр Урьдчилсан тайлан боловсруулж, танилцуулах үе шат: - 2025 оны 11 дүгээр сарын 25-28-ны өдөр Эцсийн тайлан хүлээлгэн өгөх үе шат: - 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр
	Тайлангийн бүтэц, агуулга	Үнэлгээний тайлан дараах бүтэцтэй байна. Үүнд: 1.Танилцуулга (бодлогын танилцуулга, үнэлгээ хийх үндэслэл, ач холбогдол, тухайн үнэлгээ хийж байгаа бодлогын хэрэгжилтийн товч танилцуулга, үнэлгээг хийж буй багийн танилцуулга гэх мэт) 2.Үнэлгээний зорилго, хамрах хүрээ (үнэлгээний зорилго, зорилт, хэрэгжүүлсэн арга хэмжээ, хамрах хүрээ, үнэлгээнд оролцсон хэлтэс, тасаг гэх мэт) 3.Үнэлгээний арга, аргачлал (үнэлгээ хийхэд ашигласан арга, аргачлал, өгөгдөл мэдээлэл цуглуулсан арга, хэрэгсэл, судалгааны хязгаарлалт, бэрхшээл гэх мэт) 4.Үнэлгээний олдвор (үнэлгээний шалгуурын дагуу хийсэн шинжилгээгээр тухайн бодлогод нийцсэн, бодитой зөвлөмж гаргахад үндэслэл болох ололт амжилт, алдаа дутагдал тус бүрээр тодорхойлж дүгнэх гэх мэт) 5.Үнэлгээний дүгнэлт (бодлогын үр дүнг дүгнэх, бодлогын ололт амжилт, алдаа дутагдлыг шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг онцлон тэмдэглэх, оролцогч талуудын санал, хүсэлт, үнэлгээний багийн гишүүдийн зөрүүтэй саналыг нэгтгэн дүгнэх гэх мэт) 6.Зөвлөмж (үнэлгээний олдвор тус бүрд тулгуурлан бодлогын үр өгөөжийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн бодлогод тусгах өөрчлөлт, шинэчлэлтийн талаар өгөх зөвлөмж гэх мэт) 7.Сайн туршлага ба сургамж (бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас гарсан сайн туршлага, тулгарсан сорилт, тэдгээрийг хэрхэн давах туулсан талаарх мэдээлэл, олж авсан сургамж, цаашид хэрэгжүүлэх бодлогод тусгаж болох санал гэх мэт) 8.Хавсралт (судалгааны нэмэлт материал, өгөгдөл, хүснэгт зурвалж, график оролцогч талуудын санал

		асуулга, ярилцлагын хураангуй, судалгааны мэдээлэл, нотлох баримт гэх мэт)
	Үнэлгээний шалгуур үзүүлэлт	ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалд заасан бодлогын хэрэгжилт, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрсэн түвшин, зорилтот үр дүн
	Үнэлгээний баг, оролцогч талуудын үүрэг	Үнэлгээний багийн гишүүдэд тавигдах шаардлага: - Судалгааны арга зүй эзэмшсэн байх; - Тухайн бодлогын чиглэлээр ойлголттой байх; - Бодлого төлөвлөлт, үнэлгээ, хяналт-шинжилгээний чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байхд - Ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчилгүй байх;
	Санхүүгийн төлөвлөгөө	Үнэлгээ хийхэд шаардагдах санхүүгийн задаргаа: - Бичиг хэргийн зардал (бичгийн цаас, принтерийн хор гэх мэт) - Урамшуулал (хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгжээс бусад нэгжийн албан хаагчид үнэлгээний багт ажилласан тохиолдолд урамшуулал олгоно.)
	Чанарын хяналт, тавих шалгуур	Бодлогын баримт бичгийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын холбогдох хавсралтын дагуу хүлээн авна.
	Эцсийн тайлан	Үнэлгээний эцсийн тайланд дараах зүйлийг хавсаргана. - Нотломж (илтгэх хуудас, зураг гэх мэт) - Баримт бичгийн хувь (эх болон хувилсан байж болно) - Гарын үсэг, тамга, тэмдгийн бүрдлийг хангасан байх - Тоо баримт, үр дүнг тооцоолсон байх - Хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаасан байх

ХЯНАСАН:


СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН ДАРГА



(С.ТУУЛМАА)

БОЛОВСРУУЛСАН:

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН,
ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



(Л.ОЮУНДАРЬ)